

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



БАРИЛГЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА 2019

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН



Хянасан:

Д. Мөнхзул

ЧДСХ-ийн дарга

Танилцуулгыг нэгтгэн, боловсруулсан:

У. Уртнасан

ЧДСХ-ийн мэргэжилтэн



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Монгол Улс, Улаанбаатар хот

Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж,

Нийслэлийн Засаг захиргааны III байр, 401 тоот

Утас : 70130767, 70110767

Цахим хуудас : www.ubstat.mn,

www.chingeltei.gov.mn

И-мэйл: chingeltei@nso.mn

ГАРЧИГ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	4
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ.....	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	5
1. ОРШИЛ.....	6
2. БАРИЛГЫН САЛБАРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР	
2.1 Барилгын салбарын тухай ойлголт, тодорхойлолт.....	7
2.2 Барилгын салбарын албан ёсны статистик мэдээллийн эх үүсвэр, урсгал	8
2.3 Барилгын салбарын хамрах хүрээ.....	9
3. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН БАРИЛГАЖИЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	10
4. ДҮГНЭЛТ.....	18

ЗУРАГ

Зураг 1. Чингэлтэй дүүргийн бүртгэлтэй ААНБ, салбараар, жилийн бүрийн эцэст, 2014-2019 он.....	11
Зураг 2. Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо, жил бүрийн эцэст, 2014-2019 он.....	11
Зураг 3. Барилгын салбарын ажлын гүйцэтгэл, улирлаар, 2019 он.....	12
Зураг 4. Барилга угсралт, их засварын ажил, нийт хөрөнгө оруулалтаар, сая.төгрөгөөр, 2014-2019 он.....	13
Зураг 5. Барилга угсралт, их засварын ажилын бүтэц.....	14
Зураг 6. Дүүрэгт ашиглалтад орсон барилга угсралт, их засварын ажил, хөрөнгийн эх үүсвэр, гүйцэтгэсэн төсөв, сая төгрөгөөр, 2014-2019 он.....	14
Зураг 9. Ашиглалтад орсон инженерийн барилгын ажил, зарцуулсан зардал, сая төгрөгөөр, 2014-2018 он.....	15
Зураг 10. Хүн амын хөдөлмөр эрхлэлт, салбараар, 2015-2019 он.....	17

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Барилгын салбарын аж ахуйн нэгжийн тоо, 2014-2019 он.....	12
Хүснэгт 2. Барилга угсралт, их засварын ажлын эзлэх хувь, өмчийн хэлбэрээр, 2014-2019 он.....	12
Хүснэгт 3. Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэсэн төсөвт өртгийн бүлгээр, 2014-2019 он.....	13
Хүснэгт 4. Ашиглалтад орсон барилга угсралт, их засварын ажил, хөрөнгийн эх үүсвэр, гүйцэтгэсэн төсөв, сая төгрөгөөр, 2014-2019 он.....	14
Хүснэгт 5. Төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдэж, ашиглалтад орсон барилга угсралт, их засварын ажлын эзлэх хувь, барилгын төрөл, зарцуулсан хөрөнгөөр, сая төгрөг 2019 он.....	15
Хүснэгт 6. Хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдэж, ашиглалтад орсон барилга угсралт, их засварын ажлын эзлэх хувь, барилгын төрөл, зарцуулсан хөрөнгөөр, сая төгрөг, 2019 он....	16

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам

ТЭМДЭГЛЭЛ

М ²	метр квадрат
М ³	метр куб

1. ОРШИЛ

Улсын минь нийслэл Улаанбаатар хот хатан Туулаа эмжээрлэн, дөрвөн хайрахнаа түшиж, он цагийн шаргал хуудсанд алдар суугаа өргөсөөр ирсэн түүхтэй Чингэлтэй дүүргийн түүхэн болон өнөө цагийн байдлыг хөрөнгө оруулалтай холбон статистик тоон мэдээллээр тольдон хүргэж байна.

Тэрхүү дөрвөн хайрханы нэг, хотын минь хойморт саяар тоолох хүн ард, живаа живаа орд өргөө, айл өрхийг нөмөрлөн ханхайгч эрмийн их Чингэлтэй хайрханыхаа 27 дахь хавраа угтаж байгаа нь их түүхийнх нь түүчээ, ирээдүй хойчийнх нь бамбар билээ.

Манай дүүрэг орчин үеийн хороолол болон уламжлалт гэр хорооллын зохицол дунд оршин байгаа нь энэ цагийн хотшлын ерөнхий шинжийг агуулах нийслэлийн хамгийн залуу дүүргийн нэг юм.

УИХ-ын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор дүүргийн нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоосон. Чингэлтэй дүүрэг нь засаг захиргааны 19 хороотой, 89.3 км.кв газар нутагтай, баруун талаараа Сонгинохайрхан , урд болон зүүн талаараа Сүхбаатар, баруун урд талаараа Баянгол дүүрэгтэй хиллэдэг.

Монгол хүн мянганы тэртээгээс өртөөлөн амьдарсан гэр сууцтай хороолол, орчин цагийн барилга хосолсон үзэмж нь Чингэлтэй дүүргийн ерөнхий төрхийг илтгэнэ. Чингэлтэй дүүрэг нь Нийслэлийн хоймрыг эзлэн оршдог бөгөөд 151 139 хүн амтай. Үүнээс 13 хорооны 119228 иргэн нь гэр хороололд, 6 хорооны 31 911 иргэн нь хотын төв хэсэгт амьдардаг.

Дүүргийн эдийн засгийн гол салбар нь банк, санхүү, худалдаа үйлчилгээ, мэдээлэл, технологи, харилцаа холбоо юм. Мөн төрийн захиргааны байгууллагын төв байгууллагууд байрладаг учир барилгын салбарын барилга угсралт, их засварын ажлууд орон сууцны барилгаас илүү оффисын зориулалттай болон худалдаа үйлчилгээний төсөвт өртөг өндөртэй барилгууд баригддаг байна. Барилгын түүхийг авч үзвэл Монгол улсын анхны их дэлгүүр Нийслэл хүрээний худалдааны гудамж буюу одоогийн барилгачдын талбайн зүүн урд хэсэгт байгуулагдаж байжээ. Улсын их дэлгүүр нь 1921 онд “Монголын харилцан туслалцах хоршооны төв дэлгүүр” нэртэйгээр анх байгуулагдаж, 1930-1960 онд одоогийн Занбазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн хоёр давхар барилгад байрлаж байсан учир “Өндөр хоршоо” хэмээн нэрлэж байв.

2. БАРИЛГЫН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

4.1 Ойлголт, тодорхойлолт



ОБЪЕКТ: Бие даасан барилга (орон сууц, үйлдвэрийн гол корпус, сургууль, цех, агуулах) буюу байгууламж (зам, гүүр, далан, суваг, нүхэн гарц) түүнтэй холбогдож хийгдэх үндсэн ба туслах чанарын бусад байгууламж, гадна инженерийн бүх төрлийн шугам сүлжээ, хийц тоноглол, барилгын талбайд хийгдэх өндөржилт, тохижилтын бүх ажил.



ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА: Барилгын багахан хэсгийг (Нийт талбайн 50 хувиас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.

ОРОН СУУЦНЫ БАРИЛГА: Хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж.



БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ: Олон төрлийн зориулалтаар шинээр буюу өргөтгөл, шинэчлэл хийх, нэгдсэн зураг төслөөр баригдах байгууламж

ИНЖЕНЕРИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ: Төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны бүүдлын талбай, усан хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга, байгууламжийн бүх ажил



УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ: Барилга, байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагаа.

2.2 Барилгын салбарын албан ёсны статистик мэдээллийн эх үүсвэр, урсгал



2.3 Хамрах хүрээ

Барилгын салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 4.0)-ын дагуу барилга угсралт, иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаа, барилгын тусгай үйл ажиллагаа гэсэн 3 дэд салбарын ажиллагааг хамруулан авч үздэг.

Барилга угсралтын үйл ажиллагаа (41) нь дотроо 1 ангитай. Үүнд:

- Барилга угсралт (4100)

Энэ ангид өөрийн хөрөнгөөр, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр гүйцэтгэж ашиглалтанд орсон орон сууцны болон орон сууцны бус барилга байгууламжуудыг барих үйл ажиллагаа багтана. Тухайн барилгын зарим хэсгийг өөр гүйцэтгэгч байгууллага эсвэл бүхлээр нь тухайн гүйцэтгэгч байгууллага гүйцэтгэж болно. Хэрэв зөвхөн барилгын үйл ажиллагааны тусгай хэсгийн үйл ажиллагаа байвал үйл ажиллагаа нь дэд салбар 43-т ангилагдана. Энэ ангид дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

- Орон сууцны бүх төрлийн барилга байгууламж барих үйл ажиллагаа, нэг өрхийн байшин, олон давхар байшин, олон өрхийн орон сууц
- Орон сууцны бус барилга байгууламжийг барих үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалттай барилга байгууламж, үйлдвэрийн зориулалттай, сургалт

семинар, хурал цуглаан хийх зориулалт бүхий танхим, өрөө; эмнэлэг, сургууль, конторын барилга; зочид буудал, дэлгүүр, худалдааны төв, зах, ресторан; онгоцны буудал; спортын байгууламж; газар доорх машин тавих зогсоолыг оруулан машины зогсоол; барааны агуулах; шашны зориулалттай барилга, байгууламж, сүм хийд - үйлдвэрлэлийн барилгыг барих, угсрах үйл ажиллагаа. Түүнчлэн орон сууцны зориулалт бүхий барилга, байгууламжийг шинэчлэх, сэргээх үйл ажиллагаа хамаарна.

Иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаа (42) нь 3 бүлэг, 3 ангитай. Үүнд:

- Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа
- Нийтийн аж ахуйн барилга угсралт
- Иргэний инженерийн бусад байгууламж үйлдвэрлэл


Барилгын тусгай үйл ажиллагаа (43) нь 3 бүлэг, 7 ангитай. Үүнд:

- Барилгыг буулгах / нураах үйл ажиллагаа
- Барилгын талбай бэлтгэх үйл ажиллагаа
- Цахилгааны байгууламж суурилуулах үйл ажиллагаа
- Ус, дулааны шугам сүлжээ, агааржуулагч суурилуулах үйл ажиллагаа
- Барилгын бусад суурилуулах үйл ажиллагаа
- Барилгыг дуусгах шатны ажил
- Барилгын бусад тусгай үйл ажиллагаа

2019 ОНЫ БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛД НИЙТ 123.4 ТЭРБУМ ТӨГРӨГ ЗАРЦУУЛСАН



ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 38.4 ТЭРБУМ ТӨГРӨГНИЙ БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛУУД ХИЙГДСЭН




3. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН БАРИЛГАЖИЛТ БА ӨНӨӨГИЙ БАЙДАЛ

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа барилга байгууламж, барилга угсралт, их засварын ажил, инженерийн барилгын ажлуудыг болон дүүргийн нутаг дэвсгэрт барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд, барилгын салбарын хөдөлмөр эрхлэлт, хяналт шалгалт, дүүргийн орон сууцны мэдээлэл зэргийг 2019 оны жилийн эцсийн байдлаар статистик тоо мэдээллүүд байна.

Дүүргийн хэмжээнд бизнес регистрийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар 16601 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагаас 1385 буюу 6.2 хувь нь барилгын салбарт хамаарч байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт аж ахуйн нэгж, байгууллагын дүнд барилгын салбарын аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувийг 2014 оныхтой буюу 6 жилийн өмнөхтэй харьцуулахад 2.9 пункт, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 пунктээр тус тус буурсан байна. Үүнээс үзэхэд сүүлийн 6 жилийн хугацаанд барилгын салбарын аж ахуйн нэгж, байгууллагууд тогтмол түвшинд байна /Зураг 1/.

Зураг 1. Чингэлтэй дүүргийн бүртгэлтэй ААНБ, салбараар жилийн бүрийн эцэст, 2014-2019 он



Барилгын салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг 2014 онд тогтмол үйл ажиллагаа явуулж байсан байгууллагуудтай харьцуулахад 24 буюу 5 пунктээр өсч, 2018 оныхоос 166 буюу 25.8 пунктээр буурсан байна. Бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага болон үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг харьцуулахад 45.7-51.2 хувь нь үйл ажиллагаагаа хэвийн явуулдаг байна /Зураг 2/

Зураг 2. Барилгын салбарын ААНБ-ын тоо, жил бүрийн эцэст, 2014-2019 он




2019 онд 1385 бүртгэлтэй аж ахуй нэгж байсан бөгөөд 715 нь үйл ажиллагаагаа тогтмол явуулсан.

Барилгын салбар нь тогтмол өссөлттэй салбар болох нь харагдаж байна.

Хүснэгт 1. Барилгын салбарын аж ахуйн нэгжийн тоо, 2014-2019 он

Он	Бүртгэлтэй	Үйл ажиллагаа явуулж байгаа	Эзлэх хувь
2014	927	454	49
2015	1 111	513	46.2
2016	1 210	592	48.9
2017	1 288	639	49.6
2018	1 259	644	51.2
2019	1 385	715	51.6

Хүснэгт 1.1 Барилгын салбарын аж ахуй нэгжийн тоо хороогоор, 2014-2019



6-р хороонд үйл ажиллгаа явуулдаг барилгын хуулийн этгээд хамгийн их байдаг бол 8-р хороонд хамгийн бага байдаг. /Хүснэгт 1.1/

Барилгын салбар нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг учир хийгдсэн ажлыг төсвийн зарцуулалтаар авч үзвэл 2, 3 дугаар улирлуудад өндөр буюу ажлын явц их байдаг байна.

Зураг 3. Барилгын салбарын ажлын гүйцэтгэл, улирлаар, 2019 он



Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг улирлаар авч үзэхэд 2019 оны нэгдүгээр улиралд нийт ажлын 4 хувь, хоёрдугаар улиралд 40 хувийг, гуравдугаар улиралд 35хувийг, дөрөвдүгээр улиралд 21 хувийг хийж гүйцэтгэсэн байна /Зураг 3/.

Хүснэгт 2. Барилга угсралт, их засварын ажлын эзлэх хувь, өмчийн хэлбэрээр, 2014-2019 он .

Он	Нийт	Төрийн өмчийн байгууллагын гүйцэтгэсэн ажлын хувь	Хувийн байгууллагын гүйцэтгэсэн ажлын хувь
2014	100	0	100
2015	100	2.7	97.3
2016	100	0	100
2017	100	0	100
2018	100	2.2	97.8
2019	100	0.8	99.2


2019 онд гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлыг өмчийн хэлбэрээр авч үзвэл 99.2 хувийг хувийн байгууллагын гүйцэтгэсэн ажил, 0.8 хувийг төрийн өмчийн байгууллагын гүйцэтгэсэн ажил эзэлж байна. Цаашид ч хувийн байгууллагын гүйцэтгэлийн хувь нийт барилга угсралт, их засварын ажлын дүнд дийлэнх хувийг эзлэх хандлага хэвээр хадгалагдахаар байна.

Хүснэгт 3. Барилга угсралт, их засварын ажил, гүйцэтгэсэн төсөвт өртгийн бүлгээр, 2014-2019 он.

Он	Барилга угсралт, их засварын ажлын тоо	Бүгд	10 сая төгрөг хүртэл	10-50 сая	51-100 сая	101-500 сая	500 сая төгрөгөөс дээш
2014	94	100	10.6	23.4	9.6	26.6	29.8
2015	75	100	4	21.3	12	20	42.7
2016	55	100	7.4	22.2	3.7	23.6	43.1
2017	77	100	2.6	31.2	15.6	18.1	32.5
2018	142	100	3.5	26	19.7	20.4	30.4
2019	86	100	1.2	26.7	14.0	18.6	39.5


Барилга угсралт, их засварын ажлуудыг гүйцэтгэсэн төсөвт өртгөөр тооцсон бүлэглэлтийг 2014 оноос 2019 оны хооронд авч үзвэл 2014 оны жилийн эцэст 94 объект бүртгэгдсэний 26 буюу 28.1 хувь нь 500 саяаас дээш төгрөгийн гүйцэтгэлтэй ажлууд байна. Сүүлийн 5 жилийн хандлагаас 2015, 2016 онуудад 500 сая төгрөгөөс дээш өртөг хамгийн өндөр харагдаж байгаа боловч Зураг 4-тэй харьцуулан үзэхэд нийт төсөвт өртөг нь бага байгаа нь тухайн жилийн гүйцэтгэсэн ажилд эзлэх хувь гэдгийг харуулж байгаа юм. Хийгдсэн ажлуудын өртгийг үзэхэд нийт ажлын 30-аас дээш хувь нь 500 сая төгрөгөөс дээш өртгөөр бүтсэн ажлууд хийгдэж байгаа нь барилгын салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж байгааг нөгөө талаас барилгын салбарын өртөг өндөр байгааг харуулж байна /Хүснэгт 3/.

Зураг 4. Барилга угсралт, их засварын ажил, нийт хөрөнгө оруулалтаар, сая.төгрөгөөр, 2014-2019 он



Барилга угсралтын ажилд орон сууцны болон орон сууцны бус барилгууд, инженерийн байгууламжууд багтаж байгаа бөгөөд 2014 оноос 2019 оны хооронд хийгдсэн барилга угсралтын ажил болон их засварын ажлуудыг зарцуулсан хөрөнгө оруулалтаар нь авч үзлээ. Сүүлийн 6 жилийг авч үзэхэд 2019 онд 123.5 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтын ажил хийгдэж 2015, 2016 онуудад хөрөнгө оруулалтын ажлууд бүүрсан бол 2017 онд өмнөх оноос 37.7 тэрбум буюу 90.3 хувиар огцом өсөж, 2019 онд өмнөх оноос 20.1 тэрбум буюу 20.2 хувиар нэмэгдсэн байна. 2016 оноос хойш барилгын салбарын хувийн болон төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байгааг харж болохоор байна. /Зураг 4/.

Зураг 5. Барилга угсралт, их засварын ажлын бүтэц, 2018-2019 он



Барилга угсралт, их засварын ажлыг бүтцийг хийгдэж байгаа ажлын тоогоор нь авч үзвэл 2019 онд орон сууцны бус барилга хамгийн их хувийг, их засварын ажил хамгийн бага буюу 1 хувийг эзлэж байна. /Зураг 5/.

Хүснэгт 4. Дүүрэгт ашиглалтад орсон барилга угсралт, их засварын ажил, хөрөнгийн эх үүсвэр, гүйцэтгэсэн төсөв, сая төгрөгөөр, 2014-2019 он

	2014	2015	2016	2017	2018	2019
Нийт байгууламж	140 836.9	29 676.9	40 839.5	54 598.3	67 372.4	56 799.4
Төсвийн хөрөнгө оруулалтаар бүтсэн байгууламж	82 639.0	16 319.8	21 968.1	8 727.1	18 609.3	40 328.4
Хувийн хөрөнгө оруулалтаар бүтсэн байгууламж	58 197.9	13 357.1	18 871.4	45 871.2	47 763.1	16 471.0

Ашиглалтанд орсон барилга байгууламжийн 71 хувь нь төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ба 29 хувийг хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан байна. /Хүснэгт 4/

Хүснэгт 5. Төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдэж, ашиглалтад орсон барилга угсралт, их засварын ажлын эзлэх хувь, барилгын төрөл, зарцуулсан хөрөнгөөр, сая төгрөг 2019 он.

Барилгын төрөл	Хөрөнгө оруулалт сая төгрөг	Хувь
Нийт дүн	38 447.7	100
Эрчим хүчний	2 081.5	5.4
Орон сууцны бус барилга	13 474.1	35.0
Орон сууцны барилга	2 950	7.7
Орон сууцны бус засварын ажил	1 774.6	4.6
Зам, талбайн ажил	10 433.9	27.1
Сургууль, цэцэрлэг	7 733.6	20.1

Төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хийгдсэн ажлын 35.0 хувийг орон сууцны бус барилга байгууламж эзэлж байгаа бол 27.1 хувийг зам талбайн ажлууд эзэлж байна. /Хүснэгт 5/.


Хүснэгт 6. Хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдэж, ашиглалтад орсон барилга угсралт, их засварын ажлын эзлэх хувь, барилгын төрөл, зарцуулсан хөрөнгөөр, сая төгрөг 2019 он

Бүгд	Хөрөнгө оруулалт сая төгрөгөөр	Хувь
Эрчим хүчний	46	0.3
Орон сууцны бус барилга	13 825	88.1
Орон сууцны барилга	1 820	11.6



Чингэлтэй дүүрэг нь ХХ зууны Улаанбаатарын худалдаа, үйлчилгээний гол төв байсан бөгөөд одоо ч хэвээр байгааг 2019 онд хувийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийт барилга байгууламжуудын хамгийн их буюу 88.1 хувийг орон сууцны бус барилга эзэлж байгаа нь харуулж байна. Орон сууцны бус барилгын хамгийн их нь 10.3 тэрбум төгрөг буюу 75 хувийг оффисын зориулалттай барилга, 3.5 төгрөг буюу 39.4 хувийг худалдаа үйлчилгээний зориулалттай барилга эзэлж байна. /Хүснэгт 6/

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2014-2019 ОНД АШИГЛАЛТАД ОРСОН



Төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж, ашиглалтад орсон сургууль, цэцэрлэг спорт заал, цогцолбор болон эмнэлгийн барилгуудыг 2014 оноос 2019 он хүртэл авч үзвэл 2014 оноос 2017 онуудад нийт 1200 хүүхдийн 8 цэцэрлэг, 2018 онд 715 хүүхдийн 4 цэцэрлэг, 360 суудалтай 3 сургууль, 520 суудалтай ЭМШУИС-ийн 1 сургууль, 1390 м2 талбайтай спорт цогцолбор, 2019 онд 1 тус тус ашиглалтад орсон байна. 2018 онд ерөнхий боловсролын 2538 хүүхдийн суудалтай 17.2 тэрбум төгрөгийн өртөгтэй 5 сургууль баригдаж байсан. 2019 онд ерөнхий боловсролын 3348 хүүхдийн суудалтай 26.1 тэрбум төгрөгийн 8 сургуулийн засвар, өргөтгөл, барилгын ажил явагдаж байгаа бөгөөд 23-р сургуулийн өргөтгөлийн барилга ашиглалтанд орсон.

БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

НИЙТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН АЖИЛЧДЫН ТОО

58367



БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАЖ БАЙГАА АЖИЛЧДЫН ТОО

6625



Дүүрэгт 2019 онд нийт үйл ажиллагаа явуулж байгаа 8776 аж ахуй нэгжид 58367 ажилчид ажиллаж байна. Барилгын салбарт 715 аж ахуй нэгжид 6625 хүн ажилдаг буюу 11.4 хувийг эзэлдэг.

Эрчим хүчний ажил:

Дүүргийн хэмжээнд 2019 онд 2152.3 сая төгрөгийн эрчим хүчний гэрэлтүүлэг, цахилгааны хангамжийн ажил хийгдсэнээс 97.9 хувийг төсвийн хөрөнгө оруулалтаар 2.1 хувийг хувийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн байна. Хувийн хөрөнгө оруулалтаар үйлдвэр үйлчилгээ



болон сууцны барилгуудын цахилгаан хангамжуудын ажлууд хийгддэг бол улсын хөрөнгө оруулалтаар ихэвчлэн гудамж талбайн гэрэлтүүлгийн ажлууд хийгддэг байна.

10-р хороонд 24.7 сая төгрөгийн гэрэлтүүлэг,

13,14,15-р хороонд 109.8 сая төгрөгийн гэрэлтүүлэг,

17-р хороонд 144.9 сая төгрөгийн 85 ширхэг гэрэлтүүлэг

19-р хороо 435.5 сая төгрөгийн 235 ширхэг гэрэлтүүлэг тус тус 2019 онд ашиглалтад оржээ.

ДҮГНЭЛТ

Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа 16.6 мянган аж ахуйн нэгж байгаагаас 1.1 мянга буюу 6.2 хувь нь барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байна. Ашиглалтад орсон барилга угсралт, их засварын ажлын 71 хувийг төсвийн хөрөнгө оруулалтаар, 29 хувийг хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэжээ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдсэн ажлуудыг салбараар нь авч үзвэл орон сууцны бус барилга хамгийн их буюу 13474.1 сая 35.0 хувийг, зам талбайн ажил 10433,9 сая 27.1 хувийг эзлэж байна. Харин хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэгдсэн барилга угсралт, их засварын ажлын 13825.0 сая төгрөг 73 хувийг орон сууцны бус барилга буюу худалдаа үйлчилгээ, контор, үйлдвэрлэлийн барилга эзлэж байна. Үүнээс Чингэлтэй дүүрэг хотын төвийн худалдаа үйлчилгээ төвлөрсөн бүс болох нь харагдаж байна. Харин барилгын төрлөөр авч үзэхэд орон сууцны барилга бага байна.



АНХААР !!!

**БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ЯВАГДАЖ
БАЙНА.**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ ТА БИДНЭЭС ЭХЛЭНЭ.